

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Д/д	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа												Биелэлт	Хувь
			I улирал			II улирал			III улирал			IV улирал				
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1.1.	Төрийн үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, зохицуулалтаар хангах	1.1.1.Хэлтсийн дарга нар хэлтсийнхээ тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тогтоосон хугацаанд газрын даргаар, ажилтнууд хэлтсийн дарга нараар тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах													Хэлтсийн дарга нар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт 100 ажилтан хэлтсийн дарга нараар албан хаагчийн гүйцтгэлийн төлөвлөгөөг тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100 хувь
		1.1.2.Газрын даргын баталсан албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэж буй эсэхэд хяналт шинжилгээ хийх													Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/666 дугаар “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэн батлах тухай Захирамж батлагдсан. Тус Захирамжийг батлуулах ажлын хүрээнд газрын чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийн Газрын даргад тайлагнав.	100 хувь
		1.1.3.Газрын цахим хуудас http://invest.ub.gov.mn/ -т ажлын байрны нээлттэй зар, ажилтан, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн, мэдээ мэдээллийг тухай бүр байршуулах													Ажлын байрны сул орон тоог газрын албан ёсны вэб invest.ub.gov.mn , https://erp.ulaanbaatar.mn/ сайтад нийт 15 ажлын байрны нээлттэй зарыг байршуулав. Үүнд: -Захиргааны хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн-5 -Санхүү, аж ахуйн хэлтсийн Хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн-1,	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															-Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн-5, -Барилга захилагчийн хэлтсийн Ус хангамж, ариутгах татуургын хяналтын инженер-1, -Зураг төслийн хяналтын хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер-1 -Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн Барилгын хяналтын инженер-1, -Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн-1 Хүний нөөцийн мэдээллийг тухай бүр шинэчлэв. Хүний нөөцийн хөдлөл, шилжилт хөдөлгөөний талаарх тайланг жилийн эцсийн байдлаар хэлтсийн даргад тайлагнан, гарын үсгээр баталгаажуулав.	
		1.1.4.ERP нэгдсэн системийг бүрэн ашиглах (албан бичиг хүлээх авах, илгээх, шийдвэрлэх, зөрчлийн мэдээлэл, хос бичиг эрхлэх)													2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар манай газарт 4613 албан бичиг ирснээс хариутай 1214, хариугүй 3399 байна. Үүнээс хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн албан бичиг 6, албан бичгийн шийдвэрлэлт 99,7 хувьтай байна. Газраас нийт 5756 албан бичиг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уруу илгээснээс хариутай албан бичиг 2843, хариугүй албан бичиг 2913 байна. Явсан албан бичгийг баримт боловсруулалт цэсд байршуулан тоон гарын үсгийн төхөөрөмжөөр баталгаажуулж, программд хадгалан, үлдэх хувийг цаасан хэлбэрээр архивын нэгж болгон хадгалж байна.	99,7 хувь
		1.1.5.ERP нэгдсэн системийг бүрэн ашиглах (өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэлт, зөрчлийн мэдээлэл, хэрэгжүүлэх ажлын													Газрын “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2025 оны 01 дүгээр	97.6 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		төлөвлөгөө, хариу арга хэмжээ авах)													сарын 08-ны өдөр газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг газрын даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр албажуулан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр хүргүүлэн ажиллав. Үүнд: -Нэгдүгээр улирлын тайланг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр 01/1203 дугаар албан бичгээр, -Хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 01/2644 дүгээр албан бичгээр, -Гуравдугаар улирлын тайланг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/4128 дугаар албан бичгээр, -Жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/5722 дугаараар албан бичгээр тус тус хүргүүлэв.	
		1.1.6.ERP нэгдсэн системийг ашиглах (Archive.eDoc)													Төрийн архивд цахим нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хүрээнд газрын даргын 2024 оны хүний нөөцийн чиглэлээр гаргасан 157, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 191 тушаалуудыг "UB ERP" Archive eDoc программд агуулга тодорхойлон шивж, цахим архив үүсгэв. Мөн Нийслэлийн архивын газрын зааварлагч арга зүйч Э.Наранцацралд pdf файлаар хүлээлгэн өгөв.	100 хувь
		1.1.7.ERP нэгдсэн системийг ашиглах (Хүний нөөцийн бүртгэл, цаг ашиглалт, уулзалт, үүрэг даалгавар)													"UB ERP" нэгдсэн системийн хүний нөөцийн удирдлага, цаг бүртгэл хэсгийг бүрэн хөтөлж, хэрэгжилтийг	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															хангуулан, хяналт тавин ажиллаж байна.	
		1.1.8.ERP нэгдсэн системийг ашиглах (Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар)													“UB ERP” нэгдсэн системийн Ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар хэсэгт Газрын даргын 2025 онд батлагдсан “Ажлын хэсэг байгуулах” тухай тушаалыг бүрэн байршуулан, хэрэгжилтийг хангуулан, хяналт тавин ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 64 тушаалыг байршуулж, хянагдаж дуусав. Тушаалын хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар нэгтгэн хэлтсийн даргад тайлагнан, гарын үсгээр баталгаажуулав.	100 хувь
		1.1.9.ERP нэгдсэн системийг ашиглах (Шийдвэр дэд хэсэг-ublegal.ulaanbaatar.mn)													Тайлант хугацаанд Газрын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 154 тушаалын төсөл ERP нэгдсэн системийн шийдвэр дэд хэсэгт бүрэн байршуулав.	100 хувь
		1.1.10.ERP нэгдсэн системийг ашиглах (Хүний нөөцийн сургалт хөгжил дэд хэсэг-ublegal.ulaanbaatar.mn)													Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс сар бүр зохион байгуулдаг төлөвлөгөөт сургалтад 23 удаа, 135 албан хаагч хамрагдан, мэдээллийг тус системийн Сургалт хөгжил дэд цэсэд тухай бүр бүртгэн ажиллав.	100 хувь
		1.1.11.ERP нэгдсэн системийг ашиглах (ublegal.ulaanbaatar.mn)													Тайлант хугацаанд ublegal.ulaanbaatar.mn нэгдсэн системд байршуулсан мэдээлэл байхгүй.	-
		1.1.12.Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, бүртгэл хөтлөн ажиллах													Газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/75 дугаар тушаалаар Хөдөлмөрийн гэрээ болон Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загварыг шинэчлэн батлуулсан.	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/78 дугаар тушаалаар тус Хөдөлмөрийн гэрээнд 2 заалт нэмэлт өөрчлөлт оруулан тус тус батлагдсан. Хэрэгжилтийг ханган урт хугацааны чөлөө, хүүхэд асрах чөлөө, туршилтын хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд байнгын ажлын байранд хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байгуулав. Тайлант хугацаанд 125 ажилтантай хугацаатай болон хугацаагүй Хөдөлмөрийн гэрээ болон Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулан бүртгэл хөтөлж ажиллав.	
		1.1.13.Нийт ажилтнуудад хамааралтай болон хуульд заасан, нийтэд мэдээлэх боломжтой захирамж, тушаалыг тухай бүр мэдээлэх													Тайлант хугацаанд нийт ажилтнуудад хамааралтай болон хуульд заасан дараах захирамж, тушаалыг мэдээлэн ажилласан. Үүнд: -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Бүтээн байгуулалтын жил" болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжийг нийт хэлтсийн даргад нарт танилцуулав. -Нийслэлийн Засаг даргын бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн "Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/62 дугаар захирамжийг Дотоод сүлжээнд байршуулан албан хаагч нарт танилцуулав. -Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн "Эзэнгүй муур, нохой барих нэгдсэн арга хэмжээ зохион	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															байгуулах тухай А/50 дугаар тушаалыг албан хаагч нарт танилцуулан хэрэгжилтийг тус тус ханган ажилласан. Мөн газрын даргын нийтэд мэдээлэх боломжтой тушаалыг тухай бүр газрын вэб хуудас (invest.ub.gov.mn)-т нийтлэн ажиллав.	
		1.1.14.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, тухайн оны төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг Газрын цахим веб хуудас (invest.ub.gov.mn)-т тухай бүр нийтлэх													Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/49 дүгээр тушаалаараа батлуулав. Хагас жилийн байдлаар 98.7 хувь, гуравдугаар улирлын байдлаар 98.86 хувийн биелэлттэй газрын цахим веб хуудас (invest.ub.gov.mn)-т байршуулав.	100 хувь
1.2.	Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах	1.2.1.Нэгдсэн сургалт хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд ирүүлсэн саналыг үндэслэн тус төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх													2025 оны сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг нийт ажилтнуудаас авч нэгтгэн, хэлтсийн дарга болон газрын даргад танилцуулж, баталгаажуулав. Газрын "Сургалтын төлөвлөгөө"-г 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хувь хүнийг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 71 сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 1132 албан хаагч хамрагдав.	100 хувь
		1.2.2.Эрхэлж буй ажил үүрэгтэй холбогдуулан мэргэжил дээшлүүлэх сургалтад ажилтныг сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэх													Эрхэлж буй ажил үүрэгтэй холбогдуулан мэргэжил дээшлүүлэх сургалтад ажилтныг сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон "Хөдөлмөрийн дотоод" журмын 5.2.7. дахь заалтын дагуу 2025 онд гадаад томилолтоор сургалт 3 удаа, 23 албан хаагч, дотоод сургалт 14 удаа, 718 албан хаагч,	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															мэргэшүүлэх сургалт 41 удаа, 170 албан хаагч, зөвлөгөөн, семинар, хэлэлцүүлэг 12 удаа, 158 албан хаагч, хувь хүний хөгжлийн сургалт 1 удаа, 60 албан хаагч тус тус хамрагдав.	
		1.2.3.Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сертификат олгох сургалтад хамруулах													Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 71 албан хаагч АЗ шалгалт өгч тэнцэн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг шинээр авав. Жилийн эцсийн байдлаар 86 албан хаагч гэрчилгээ эзэмшиж байна.	100 хувь
		1.2.4.“ФИДИК”-ийн гэрчилгээний эрх олгох сургалтад инженер, холбогдох мэргэжилтнийг хамруулах													Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Өмгөөллийн Батбаяр энд партнэрс” ХХН хамтран 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохин байгуулсан Олон Улсын “ФИДИК” гэрээний сургалтад 2 инженер хамрагдав. Жилийн эцсийн байдлаар “ФИДИК” гэрээ байгуулах эрхтэй 17 албан хаагч байна.	100 хувь
		1.2.5.“Нэгдсэн менежментийн тогтолцоо” MNS ISO 9001:2015, MNS ISO 21500:2017 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд ажилтныг төлөвлөгөөт сургалт зохион байгуулах													Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015, Төслийн менежментийн арга зүйн заавар MNS ISO 21500:2017 стандартыг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Ажлын хэсэг, чанарын багийг шинэчлэн томилох тухай” А/36 дугаар тушаал батлагдан холбогдох сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулан нийт албан хаагчид хамрагдав. Ажлын төлөвлөгөөг газрын даргаар 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															батлуулан, хэрэгжилтийг ханган, амжилттай нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд “Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015, Төслийн менежментийн арга зүйн заавар MNS ISO 21500:2017 стандарт”-ыг нэвтрүүлэн, баталгаажуулалтын гэрчилгээгээ амжилттай сунгуулж, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Чанарын багийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүн гардан авсан.	
		1.2.6.Ажилтнуудыг Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах													Газрын Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 4 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 205 ажилтан хамрагдсан. Үүнд: 1.2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Хууль зүйн доктор, судлаач багш Л.Мөнх-Эрдэнэ удирдан зохион байгуулав. Сургалтад нийт 48 ажилтан, 2.Газрын “Ёс зүйн дэд хороо”-ны 2025 оны төлөвлөгөөний дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, нийт 29 ажилтан, 3.2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Я.Батханд удирдан зохион байгуулж, нийт 84 ажилтан, 4.2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Ажлын байрны бэлгийн	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Хууль зүйн ухааны доктор, судлаач багш Л.Мөнх-Эрдэнэ удирдан зохион байгуулав. Сургалтад нийт 44 ажилтан тус тус хамрагдав.	
		1.2.7.Авлига ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах													Авлига ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг нийт 3 удаа зохион байгуулж, 202 ажилтан хамрагдав. Үүнд: 1.2025 оны 06 дугаар сарын 19-ны өдөр "Ашиг сонирхол ба нөлөөлөх хүчин зүйл" сургалт, нийт 50 ажилтан, 2.2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Я.Батханд багштай хамтран "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, 84 ажилтан, 3.2025 оны 10 дүгээр сарын 19-ны өдөр Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Л.Содбаяр багштай хамтран “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сургалт, нийт 68 ажилтан тус тус хамрагдав.	100 хувь
		1.2.8.Хууль тогтоомж эрх зүйн баримт бичиг, шинэчлэл, стандартын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах													Нийслэлийн прокурорын газартай хамтран 2025 оны 10 дүгээр сарын 19-ны өдөр Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Л.Содбаяр “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” сургалтыг зохион байгуулан нийт 68 ажилтан хамрагдав.	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		1.2.9.Үндсэн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэх, форум, семинарт ажилтнуудыг тухай бүр хамруулах													2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар газрын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөөн, семинар, хэлэлцүүлэг, уулзалт 12 удаа зохион байгуулагдаж, 158 ажилтан хамрагдав.	100 хувь
		1.2.10.Ажилтнуудыг НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан сургалтад тухай бүр хамруулах													Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн төлөвлөгөөг сар бүр хэлтсийн дарга нарт танилцуулан, санал авч нэгтгэн, хүргүүлж, ажилтнуудыг тухай бүр хамруулан ажиллав. Тайлант хугацаанд нийт 23 сургалтад давхардсан тоогоор 135 ажилтан хамрагдав	100 хувь
		1.2.11.Ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах													“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-ын тухай хууль, Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/50 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” журмын хэрэгжилтийг хангахаар “Ололт, Амжилт” сургалтын төвтэй хамтран нийт ажилтнуудад зориулсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулагдав.	100 хувь
		1.2.12.Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж амьдрах тухайд чиглэсэн сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах													Газрын ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж амьдрах тухайд чиглэсэн “Health education academy”-тай хамтран “Эрүүл зөв хооллолт болон Хавдраас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулав.	100 хувь
		1.2.13.Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх ойлголт, мэдлэг,													Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/31 дүгээр	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		хандлага, түүнээс сэргийлэх, хамгаалах, талаар ойлголт, мэдлэг, хандлага, түүнээс сэргийлэх, хамгаалах, талаар хууль тогтоомжийн хүрээнд сургалт зохион байгуулах													тушаалаар Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажлын хэсгийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Газрын ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээллийг шалгах Ажлын хэсгийн 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Газрын даргад танилцуулан, баталгаажуулсан. Хэрэгжилт 97,1 хувьтай. Тайлант хугацаанд гомдол мэдээлэл ирээгүй байна. Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалын долдугаар хавсралтын дагуу Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой санал асуумжийг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 05-ны өдрийн хооронд цахимаар авч, нийт 51 ажилтан хамрагдан дүн мэдээг нэгтгэн тайлагнав. 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг Хууль зүйн ухааны доктор, судлаач багш Л.Мөнх-Эрдэнэ удирдан зохион байгуулж, нийт 44 ажилтан, хамрагдав.	
		1.2.14.Албан хэрэгцээний техник хэрэгслийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэх заавар, арга													Албан хэрэгцээний техник хэрэгслийг өдөр тутмын үйл ажилгаанд хэрэглэх арга зүйн	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		зүйн зөвлөгөө өгөх сургалтыг ажлын байранд зохион байгуулах													зөвлөгөө, зааврыг өгөх сургалтыг ажилтнуудад Мэдээллийн технологийн хэлтсээс давхардсан тоогоор нийт 579 удаа өгч ажиллав.	
		1.2.15.Үндэсний бичгийн анхан, дунд шатны сургалтыг зохион байгуулах													Чой.Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн эрдмийн хүрээлэнтэй хамтран газрын нийт ажилтнуудаас монгол бичгийн түвшин тогтоох судалгааг 2025 оны 01 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд дотоод сүлжээгээр google.doc form ашиглан цахим хэлбэрээр авч, дүнг нэгтгэн газрын удирдлагад танилцуулав. Монгол бичгийн сургалтыг тус хүрээлэнтэй хамтран зохион байгуулах ажлын гэрээний төслийг Хууль, дотоод хяналтын хэлтсээр хянуулж, гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангасан боловч 2026 онд зохион байгуулагдахаар хойшлуулав.	50 хувь
		1.2.16.Гадаад оронд туршлага судлах сургалт, үзэсгэлэнд хамруулах													2025 оны жилийн эцсийн байдлаар гадаад сургалт 3 удаа, нийт 23 ажилтан хамрагдав. Үүнд: Баруун европын орнуудад 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 18-ны өдрүүдэд туршлага судлах сургалтад 7 ажилтан хамрагдав. БНХАУ-ын Саньяа Хайнань мужад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд “Нийслэлд хэрэгжүүлэх ижил төстэй томоохон бүтээн байгуулалтын төсөлд хяналт тавих тал дээр мэдлэг, мэдээлэл туршлага солилцох, хуримтлуулах” сургалтанд 16 ажилтан хамрагдав. БНХАУ-ын Гуанжоу хотод 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 27-ны өдрүүдэд	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															“Барилгын үзэсгэлэн худалдаа”-нд 1 ажилтан оролцов.	
1.3	Хүний нөөцийн менежмент, бодлогын ил тод нээлттэй байдлыг хангах	1.3.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарын хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэн баталж мөрдөн ажиллах													Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/666 дугаар захирамжаар тогтоосон бүтэц, орон тооны хязгаарын хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 100 ажилтантай, 8 сул орон тоо байна.	100 хувь
		1.3.2.Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах													Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/666 дугаар захирамжаар тогтоосон бүтэц, орон тооны хязгаарын хүрээнд Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/46 дугаар тушаалаар нийт 56 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулав.	100 хувь
		1.3.3.Ажлын байрны сул орон тооны зар, мэдээг, тухай бүр газрын цахим хуудас invset.ub.gov.mn-т нээлттэй байршуулна цахим хуудсанд нээлттэй байршуулж, сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхөх													Газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/75 дугаар тушаалаар “Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам” батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Тайлант хугацаанд 15 ажлын байрны зар газрын цахим хаягт байршуулан тухай бүр сонгон шалгаруулалт хийж сул орон тоог нөхөн ажиллав.	100 хувь
		1.3.4.Газрын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг дээдэлсэн соёлыг төлөвшүүлэх													Газрын Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлийг дээдэлсэн соёлыг төлөвшүүлэх ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр видео дүрсээр Газрын цахим веб хуудас (invest.ub.gov.mn)-т байршуулав.	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															Мөн газрын мэдээллийн самбарт танилцуулага хэлбэрээр, ажилтан тус бүрт наалт хуудас хэлбэрээр тус тус бэлтгэн сурталчилан таниулах ажлыг зохион байгуулав.	
		1.3.5.Ажилтнуудын хувцаслалт, албан соёлыг хэвшүүлэх													Газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний дагуу 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд ажилтнуудын ёс зүй, ёс суртахууныг тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой "Ёс зүйтэй албан хаагч" үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын талаар нийт 6 удаагийн постер мэдээллийг дотоод сүлжээнд байршуулан мэдээлэл өгөв. Мөн сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр дараах сургалтад хамрагдав. Үүнд: 1."Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, 48 ажилтан, 2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх" сургалтад 3 ажилтан тус тус хамрагдав. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03/2617 дугаарын албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны харьяа байгууллагын нийт албан хаагч нарт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Ажлын байранд дээрх ёс зүйн хэм, хэмжээг мөрдөж ажиллахыг	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															анхааруулсан тухай мэдэгдлийг дотоод сүлжээнд байршуулан нийт ажилтнуудад мэдээлэл хүргэв.	
		1.3.6.Ажилтнуудын ажилласан жил, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг холбогдох тогтоол журмын хүрээнд олгох													Тайлант хугацаанд нийт 266,556,656.46 төгрөгийн ажилласан жил, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг холбогдох тогтоол журмын хүрээнд олгов.	100 хувь
		1.3.7.Ажилтын "Ёс зүйн дүрэм"-ийг мөрдлөг болгон ажиллаж, "Ёс зүйн дэд хороо"-ны тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах													Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн "дотоод журам", 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан "Ажилтны Ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулан ажиллав. Ёс зүйн дэд хороонд 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 1 гомдол, мэдээлэл ирсний дагуу 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хурал зохион байгуулж, хурлын тэмдэглэлээр баталгаажуулан дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр газрын дарга болон холбогдох нэгжийн дарга, ажилтан нарт танилцуулав. Газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Газрын даргаар батлуулан биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Газрын даргад танилцуулан, баталгаажуулав. Хэрэгжилт 93,7 хувьтай.	88,6 хувь
		1.3.8.Шинэ ажилтныг чиглүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан ажиллах													Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр А/17 дугаар тушаалаар батлагдсан "Шинэ ажилтан чиглүүлэх хөтөлбөр"-ийг хэлтсийн	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															дарга нартай хамтран 15 шинэ ажилтанд хэрэгжүүлэн ажиллав.	
		1.3.9.Ажилтны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг холбогдох хууль, журмын дагуу хагас, бүтэн жилээр дүгнэх ажлыг зохион байгуулах													Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу 2025 оны хагас жилийн байдлаар 86 ажилтан, 2025 оны бүтэн жилийн байдлаар 94 ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг дүгнэх ажлыг зохион байгуулав.	100 хувь
		1.3.10.Үнэлгээний дүнгээс хамааран мөнгөн урамшуулал олгох, шагналд тодорхойлох, холбогдох сургалтад хамруулах, сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг хэрэгжүүлэх													Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу 2025 оны хагас жилийн байдлаар 86 ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин маш сайн үнэлэгдсэн тул ажилтнуудад газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/79 дүгээр тушаал, 2025 оны бүтэн жилийн байдлаар 94 ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин маш сайн үнэлэгдсэн тул ажилтнуудад газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Б/112 дугаар тушаалаар тус тус мөнгөн урамшуулал олгов.	100 хувь
		1.3.11.Ажилтны хагас, бүтэн жилийн ажлын мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээг газрын цахим хуудас invset.ub.gov.mn-т нээлттэй байршуулах													Ажилтны хагас, бүтэн жилийн ажлын мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээг газрын цахим хуудас invset.ub.gov.mn-т нээлттэй байршуулав.	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
ХОЁР. НИЙГМИЙН БАТАЛГАА																
2.1	Ажиллах таатай орчинг бүрдүүлэх	2.1.1.Ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр төсөвт тусгах замаар шийдвэрлэн шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллах													Тайлант хугацаанд нийт 206,724,220.00 төгрөгийн шаардлага техник тоног төхөөрөмж худалдан авсан.	100 хувь
		2.1.2.Ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд ажлын өвөл, зуны хувцсаар хангаж ажиллах													Тайлант хугацаанд “Оюудаль” ХХК-тай хамтран нийт 1,160,000.00 төгрөгийн бомбер хувцсаар хангав.	100 хувь
		2.1.3.Ажилтны хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлийн чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлийг хангах, өрөө тасалгааг аятай тохитой орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах													Тайлант хугацаанд нийт 89,988,867 төгрөгийн оффисын засвар үйлчилгээ хийв.	100 хувь
		2.1.4.Ажилтнуудын сэтгэл ханамжийг жил бүр судлан, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх													2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрүүдэд газрын дотоод сүлжээгээр цахим хэлбэрээр авсан судалгаанд нийт 92 ажилтан хамрагдахаас 69 буюу 75 хувь нь хамрагдсан. Судалгааны үр дүн, тайланг нэгтгэн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хэлтсийн дарга, газрын даргад тус тус танилцуулж баталгаажуулав. Судалгааны дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг хэлтсийн дарга нарт танилцуулж, баталгаажуулан газрын дотоод сүлжээнд байршуулж, нийт ажилтнуудад мэдээлэл хүргэв.	100 хувь
		2.1.5.Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх,													Тайлант хугацаанд дээрх нөхцөл үүсээгүй.	-

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас хамгаалах														
2.2	Нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх	2.2.1.Ажилтны гэр бүлд шинэ хүн мэндэлсэн бол Хөдөлмөрийн дотоод журмын дагуу тусламж үзүүлэх													Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн "дотоод журам"-ын дагуу 11 ажилтанд 39,300,000 төгрөгийн тусламжийг тушаалаар баталгаажуулав.	100 хувь
		2.2.2.Ажилтан нь газарт 24 сар буюу түүнээс дээш жил ажилласан, анх удаа гэр бүл болж, хурим хийсэн бол хөдөлмөрийн "дотоод журам"-ын хүрээнд тусламж олгох													Газрын хөдөлмөрийн "дотоод журам"-ын дагуу 1 ажилтанд 2.500.000 төгрөгийн тусламжийг тушаалаар баталгаажуулав.	100 хувь
		2.2.3.Ажилтны төрсөн хүүхэд шинээр гэр бүл болж, хурим хийсэн тохиолдолд хөдөлмөрийн "дотоод журам"-ын хүрээнд тусламж олгох													Тайлант хугацаанд дээрх нөхцөл үүсээгүй.	-
		2.2.4.Ажилтан өөрөө болон гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү) нас барсан тохиолдолд хөдөлмөрийн "дотоод журам"-ын хүрээнд дэмжлэг олгох													Газрын хөдөлмөрийн "дотоод журам"-ын дагуу 3 ажилтанд 6.000.000 төгрөгийн тусламжийг тушаалаар баталгаажуулав.	100 хувь
		2.2.5.Ажилтны хадам эцэг, эх өөрийн өвөө, эмээ нас барсан тохиолдолд хөдөлмөрийн "дотоод журам"-ын хүрээнд дэмжлэг олгох													Ажилтны хадам эцэг, эх өөрийн өвөө, эмээ нас барсан 3 ажилтанд 1.500.000 төгрөгийн тусламж үзүүлэв.	100 хувь
		2.2.6.Ажилтны хүүхэд олон улс, тив дэлхий, улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцож 1 2, 3 дугаар байрт шалгарч амжилт гаргасан тохиолдолд хөдөлмөрийн "дотоод журам"-ын хүрээнд дэмжлэг олгох													Тайлант хугацаанд дээрх нөхцөл үүсээгүй.	-
		2.2.7.Ажилтны орон байр байгалийн гэнэтийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд даргын зөвлөлийн хурлаар													Тайлант хугацаанд дээрх нөхцөл үүсээгүй.	-

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		хэлэлцэж мөнгөн дэмжлэг үзүүлж болно														
		2.2.8.Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг орон сууцтай болгох зорилгоор ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэн ажиллах													Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан ажилтнуудад газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/72 дугаар тушаалаар дэмжлэг олгов.	100 хувь
		2.2.9.Тэтгэвэр тогтоолгох насанд хүрч ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилтанд үндсэн цалингийн хэмжээгээр 24 сар хүртэлх мөнгөн тэтгэмжийг хөдөлмөрийн "дотоод журам"-ын хүрээнд олгох													Тайлант хугацаанд дээрх нөхцөл үүсээгүй.	-
		2.2.10.Газраас тэтгэвэрт гарсан ахмадуудад жил бүр хүндэтгэл үзүүлэх													Тайлант хугацаанд дээрх нөхцөл үүсээгүй.	-
2.3	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах	2.3.1.Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор жилд нэг удаа нарийн мэргэжлийн оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах													Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ 2025 оны 04 сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, нийт 86 ажилтан, 58,600,000 төгрөгөөр хамрагдав.	100 хувь
		2.3.2.Спорт, урлагийн чиглэлээр олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий "Соёл, спортын хамтлаг" ажиллах бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллах													"Соёл, спорт хамтлаг"-ийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийн ханган жилийн эцсийн байдлаар 100 хувийн биелэлттэй ажиллав.	100 хувь
		2.3.3."Соёл, спортын хамтлаг" нь албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, 7 хоног бүр спорт зааланд чөлөөт цагаа өнгөрүүлэх, фитнес, спенинг, иог, бясалгал зэрэг төрөл бүрийн урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах													"Соёл, спорт хамтлаг"-ийн төлөвлөгөөний хүрээнд 4 төрлийн тэмцээн зохион байгуулагдав. Үүнд: 1.2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр "Гар бөмбөг", "Дартс"-ын аварга шалгаруулах тэмцээнд 5 багийн нийт 85 ажилтан, 2.2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр "Сарсан бөмбөг", "Ширээний	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															теннис"-ний аварга шалгаруулах тэмцээнд 5 багийн нийт 85 ажилтан тус тус оролцов. Мөн 7 хоног бүр спорт зааланд чөлөөт цагаа өнгөрүүлэх ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нүхтийн замд байрлах спорт заалд 2025 оны 09 сарын 17-ны өдрөөс 2025 оны 11 сарын 26-ны өдрийг хүртэл долоо хоногт 1 удаа 2 цагаар лхагва гараг бүр 18:00 цагаас 20:00 цаг хүртэл нийт 11 удаа тоглохоор гэрээ байгуулан ажиллав.	
		2.3.4.Албан хаагчдыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан тэмцээнд тухай бүр оролцуулах ажлыг зохион байгуулах ба нэгдсэн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллах													Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос 2025 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүд, 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, нийт 3 төрлийн тэмцээнд 17 ажилтан хамрагдан "Дартс"-ын тэмцээнд Э.Батцэнгэл, Э.Элдэв-Очир, Б.Туяажаргал, "Сагсан бөмбөг"-ийн тэмцээнд эрэгтэй 7, эмэгтэй 7 ажилтан тус тус оролцож, эмэгтэй баг тамирчид хүрэл медаль хүртэв. Нийслэлийн биеийн тамир, спортын газраас 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн "Хамтран ажиллах тухай" 02/82 дугаар албан бичгийн удирдамжийн дагуу зохион байгуулалтыг хангаж ажиллав. 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр "Улаанбаатар марафон 2025" олон улсын гүйлт зохион байгуулагдаж, нийт 20 ажилтан амжилттай оролцов. Дээрхи арга хэмжээнүүдэд оролцсон талаарх мэдээллийг газрын цахим хуудсаар тухай бүр нийтлэв.	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		2.3.5.Газрын соёл, манлайлал, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, багийн ажиллагааг бэхжүүлэх, хамт олны дотор ажил хэрэгч уур амьсгалыг бий болгох, харилцан бие биеэ хүндлэн ажиллах орчныг бүрдүүлэх зорилгоор Залуучуудын хөгжлийн зөвлөл, Эцэг, эхийн зөвлөлийг ажиллуулах ба тухайн жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллах													2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн өглөөний 08:00 цагт Богдхан уулын Дугуй цагаанд явган алхалтыг зохион байгуулж, нийт 3 ажилтан, 2.“Хөгжилтэй АХА” тэмцээнийг зохион байгуулж, нийт 50 ажилтан, 3.2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх, хэлтсүүдийн дотоод уялдааг сайжруулах” сургалтыг зохион байгуулж, 70 ажилтан, 4.”Цусаа бэлэглэе” сайн үйлсийн аяныг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолборын “А” блокт зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээнд нийт 6 ажилтан цус хандивлан оролцов. Залуучуудын зөвлөлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 91 хувьтай хэрэгжив. 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр газрын даргаар “Эцэг, эхийн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.“Эерэг хүмүүжлийн энгийн аргууд” сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр “Тогло Инээ Сур” ТББ-ын сургагч багш, сэтгэл зүйч Б.Сансармаа сэтгэл зүйн тест, тоглоомд тулгуурлан удирдан зохион байгуулж, нийт 54 ажилтан, хамрагдав.	93 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
															2.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Бидний жаргалтай үрс” өдөрлөгийг Чингисийн хүрээ амралтын газарт зохион байгуулав. Өдөрлөгт 50 гаруй хүүхэд, эцэг, эхчүүд оролцсо. Эцэг эхийн зөвлөлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 95 хувьтай хэрэгжив.	
		2.3.6.Цасны баяр, явган болон уулын аяллыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах													Нийслэлийн “Өвлийн спортын наадам”-ын нээлт 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр “Скай резорт” цанын баазад зохион байгуулагдаж, нийт 67 ажилтан оролцов. Бүжгийн тэмцээнд 4 ажилтан, явган алхалтын тэмцээнд эрэгтэй 6, эмэгтэй 6 ажилтан оролцож, тэргүүн байр эзэлж, цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав. 2025 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн өглөөний 08:00 цагт Богдхан уулын Дугуй цагаанд явган алхалтыг зохион байгуулж, нийт 3 албан хаагч идэвхтэй оролцов.	100 хувь
2.4	Албан хаагчдыг үр бүтээлтэй, тогтвор, суурьшилтай ажиллуулах	2.4.1.Ажлын бүтээмж, үр дүнг холбогдох журмын хүрээнд сар бүр үнэлж дүгнэн нэмэгдэл хөлс олгох													Тайлант хугацаанд 679,308,694.39 төгрөгийн нэмэгдэл хөлс олгов.	100 хувь
		2.4.2.Албан хаагчдад сар бүр унаа, хоолны мөнгөн олговрыг олгох													Тайлант хугацаанд 540,260,000.00 төгрөгийн унаа хоолны мөнгөн олговор олгов.	100 хувь
		2.4.3.Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гаргаж, үүргээ бүрэн биелүүлж, амжилт гаргасан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах													Ажлын амжилт гарган, салбартаа үр бүтээлтэй ажиллаж байгаа 32 албан хаагчийг шагнав.	100 хувь

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
		ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах														
		2.4.4.Газрын даргын нэрэмжит шагналд ажилтныг тодорхойлж шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх													Газрын даргын нэрэмжит 4 албан хаагч, байгууллагын шилдэгийн шилдэг 1 албан хаагч, шилдэг 10 албан хаагчийг тодорхойлж шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулан, нэгдсэн бүртгэл хөтлөн ажиллав.	100 хувь
		2.4.5 Ээлжийн амралтын хуваарийг батлуулж, олговрыг тухай бүр олгох													Тайлант хугацаанд 70 хүний 332,003,884.00 амралтын цалин бодож олгов.	100 хувь
Биелэлтийн дундаж хувь – 98.98 хувь																

ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС